



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод их сургуулийн Лицей сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/132/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Б.Үжин

Утас: 70003775, 89013775

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.6.1 Төсвийн төлөвлөлт	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Албан шаардлага	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДП-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.25 № 294
танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН ДОРНОД ИХ
СУРГУУЛИЙН ЛИЦЕЙ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ш.МАНДАХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод их сургуулийн Лицей сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод их сургуулийн Лицей сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгжлөгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020078

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,086,064.00</u>	<u>16,073,376.00</u>
33	АВЛАГА	288,689.00	552,590.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	288,689.00	552,590.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,797,375.00	15,520,786.00
354	Хангамжийн материал	8,797,375.00	15,520,786.00
35410	Бичиг хэргийн материал	-	552,400.00
35420	Аж ахуйн материал	-	1,246,710.00
35470	Бусад хангамжийн материал	8,797,375.00	13,721,676.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,808,926.93</u>	<u>19,292,659.34</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,808,926.93	19,292,659.34
392	Биет хөрөнгө	24,936,635.25	17,853,492.66
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,609,352.00	26,609,352.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,616,279.23)	(10,268,617.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,297,625.00	2,297,625.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(354,062.52)	(784,867.23)
393	Биет бус хөрөнгө	1,872,291.68	1,439,166.68
39301	Програм хангамж	2,310,000.00	2,310,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(437,708.32)	(870,833.32)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>35,894,990.93</u>	<u>35,366,035.34</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>288,689.00</u>	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	288,689.00	-
413	Өглөг	288,689.00	-
4136	Бусад өглөг	288,689.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	288,689.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>35,606,301.93</u>	<u>35,366,035.34</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	35,606,301.93	35,366,035.34
512	Хуримтлагдсан үр дүн	35,606,301.93	35,366,035.34
51210	Өмнөх үеийн үр дүн	35,606,301.93	35,606,301.93
51220	Тайлант үеийн үр дүн	-	(240,266.59)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>35,894,990.93</u>	<u>35,366,035.34</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	206,640,438.04	232,759,422.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,683,639.50	2,262,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,676,662.50	2,262,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,676,662.50	2,262,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,676,662.50	2,262,500.00
121	Хөрөнгийн орлого	30,006,977.00	-
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	30,006,977.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,695,898.54	63,206,922.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	131,260,900.00	167,290,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,695,898.54	63,206,922.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,835,422.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,695,898.54	58,371,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	171,034,136.11	232,999,688.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	171,034,136.11	232,999,688.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	164,309,752.33	227,739,380.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134,400,631.00	153,055,984.00
210101	Үндсэн цалин	121,319,531.00	104,298,826.00
210102	Нэмэгдэл	7,141,100.00	34,249,745.00
210104	Урамшуулал	5,940,000.00	14,507,413.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,387,300.00	19,104,600.00
210201	Тэтгэврийн даатгал	11,598,500.00	13,328,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,197,200.00	1,444,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	957,760.00	1,155,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	239,440.00	288,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,394,400.00	2,888,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,158,437.93	13,312,673.00
210401	Бичиг хэрэг	444,320.76	1,883,515.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	552,100.00
210404	Ном, хэвлэл	756,000.00	2,417,310.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,803,518.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	758,117.17	4,456,230.00
2105	Нормативд зардал	6,272,500.00	25,595,956.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,500.00	310,500.00
210502	Хоол, хүнс	6,262,000.00	25,233,356.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	52,100.00
2107	Томилолт, зочны зардал	-	96,000.00
210702	Дотоод албан томилолт	-	96,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	292,400.00	1,828,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	292,400.00	1,828,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,798,483.40	14,746,167.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	290,433.33	7,229,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,408,050.07	7,516,267.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,724,383.78	5,260,308.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	4,533,648.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	4,533,648.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,724,383.78	726,660.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,724,383.78	726,660.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>35,606,301.93</u>	<u>(240,266.59)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>35,606,301.93</u>	<u>(240,266.59)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	35,606,301.93	35,606,301.93
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	35,606,301.93	35,606,301.93
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	35,606,301.93	35,606,301.93
Тайлант үеийн үр дүн	-	-	(240,266.59)	(240,266.59)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	35,366,035.34	35,366,035.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>167,956,798.54</u>	<u>230,496,922.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>167,956,798.54</u>	<u>230,496,922.00</u>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	131,260,900.00	167,290,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,695,898.54	63,206,922.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,835,422.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,695,898.54	58,371,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>167,956,798.54</u>	<u>230,496,922.00</u>

21	УРСГАЛ ЗАРДАЛ	167,956,798.54	230,496,922.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	161,232,414.76	225,236,614.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134,400,631.00	153,608,574.00
210101	Үндсэн цалин	121,319,531.00	104,851,416.00
210102	Нэмэгдэл	7,141,100.00	34,249,745.00
210104	Урамшуулал	5,940,000.00	14,507,413.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,387,300.00	19,104,600.00
210201	Тэтгэврийн даатгал	11,598,500.00	13,328,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,197,200.00	1,444,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	957,760.00	1,155,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	239,440.00	288,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,394,400.00	2,888,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,157,483.76	14,884,584.00
210401	Бичиг хэрэг	444,320.76	2,435,200.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	89,000.00	552,100.00
210404	Ном, хэвлэл	756,000.00	2,417,310.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,602,818.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	668,163.00	6,677,156.00
2105	Нормативд зардал	6,324,600.00	25,595,956.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,500.00	310,500.00
210502	Хоол, хүнс	6,262,000.00	25,233,356.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	52,100.00	52,100.00
2107	Томилолт, зочны зардал	-	96,000.00
210702	Дотоод албан томилолт	-	96,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,502,400.00	1,828,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,502,400.00	1,828,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	460,000.00	10,118,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	360,000.00	10,118,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,724,383.78	5,260,308.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	4,533,648.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	4,533,648.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,724,383.78	726,660.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,724,383.78	726,660.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	167,290,000.00	166,563,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	167,290,000.00	166,563,340.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	167,290,000.00	166,563,340.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	144,411,500.00	143,686,856.00
210101	Үндсэн цалин	101,471,800.00	98,617,012.00
210102	Нэмэгдэл	30,359,200.00	33,062,431.00
210104	Урамшуулал	12,580,500.00	12,007,413.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,104,600.00	19,104,600.00
210201	Тэтгэврийн даатгал	13,328,000.00	13,328,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,444,100.00	1,444,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,155,300.00	1,155,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	288,800.00	288,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,888,400.00	2,888,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,522,900.00	1,520,884.00
210401	Бичиг хэрэг	98,000.00	73,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,100.00	52,100.00
210404	Ном, хэвлэл	41,700.00	41,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	497,500.00	568,984.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	833,600.00	784,300.00
2105	Нормативд зардал	362,600.00	362,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	310,500.00	310,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	52,100.00	52,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	574,500.00	574,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	574,500.00	574,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,313,900.00	1,313,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,313,900.00	1,313,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	167,290,000.00	166,563,340.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	167,290,000.00	166,563,340.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	167,290,000.00	166,563,340.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	12	12
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	1	1

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,206,922.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,206,922.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,673,274.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,921,718.00
210101	Үндсэн цалин	6,234,404.00
210102	Нэмэгдэл	1,187,314.00
210104	Урамшуулал	2,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,363,700.00
210401	Бичиг хэрэг	2,361,400.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00
210404	Ном, хэвлэл	2,375,610.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,033,834.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,892,856.00
2105	Нормативд зардал	25,233,356.00
210502	Хоол, хүнс	25,233,356.00
2107	Томилот, зочны зардал	96,000.00
210702	Дотоод албан томилот	96,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,253,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,253,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,805,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,805,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,533,648.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,533,648.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,533,648.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,206,922.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,206,922.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,835,422.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,371,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод их сургуулийн Лицей сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор Б.Үжин нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод их сургуулийн Лицей сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь: "Хүүхэд нэг бүрийн" хөгжлийн төлөө ажиллах ерөнхий боловсролын ахлах сургуулийн стандартыг хэрэгжүүлэн ажиллаж, Улсын хэмжээнд тэргүүлэгч шилдэг ахлах сургууль болох зорилготой ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод хяналтын мэргэжилтэнтэй бөгөөд тайлант онд дээд шатны болон хөндлөнгийн байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод их сургуулийн Лицей сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 131,261.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 2,625.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,969.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Авлага дансны үлдэгдэл 552,6 мянган төгрөг болж 264.0 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбоотой авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15,520.7 мянган төгрөг болж 6,723.4 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 31,217.0 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос өөрчлөлтгүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 26,119.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгаас хуваарилсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 61,965.5 мянган төгрөгөөр өссөн нь бараа ажил үйлчилгээний зардал өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 167,265.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 167,265.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны

төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 167,290.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 167,290.0 мянган төгрөгөөр тооцон төсвийн тодруулга 1 удаа хийгдсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 167,290.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 167,290.0 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 167,290.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 167,290.0 төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 166,563.3 мянган төгрөг буюу 99.6 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 726.7 мянган төгрөг буюу 0.4 хувийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дорнод аймгийн дээд шатны төсвийн захирагчаас 4,835.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгосон нэмэлт орлого 58,371.5 мянган төгрөг, нийт 63,206.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 9,921.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 13,363.7 мянган төгрөг, хоол, хүнсний зардалд 25,233.4 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 96.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,253.5 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 8,805.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 4,533.6 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дорнод Их сургуулийн Лицей сургууль нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8 орлогын 31,247.3 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 237.8 сая төгрөгийн 3 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө 2018 онд хэвлэгдсэн Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж хэрэгжүүлэх
- Дорнод аймгийн Засаг даргын тамгын газраас гаргасан Санхүү, төсвийн холбогдолтой дүрэм, журмын эмхэтгэлийн дагуу хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах
- Мэргэжлийн бус нягтлан бодогчдод зориулж нягтлан бодох бүртгэлийн арга аргачлал, төсвийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг таниулсан сургалт зохион байгуулах
- НӨАТ-ын цахим төлбөрийн баримтын бараа, ажил үйлчилгээний нэр төрлийг дэлгэрэнгүй жагсаалтаар хүлээн авч төсвийн гүйлгээг хийж байх

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 63,763.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 63,763.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

4.1 Албан шаардлага

1. Тайлант онд 14 байгууллагаас 16,456.7 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцээгүй санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Хөрөнгийн тооллогыг хангалтгүй 47,306.6 мянган төгрөгийн хөрөнгө, тушаалд заасан хугацаанд хийгээгүй, тооллогын дүн санхүүгийн тайлан дахь дүн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дорнод Их сургуулийн Лицей сургууль	3	63.7	-	-	-	-	3	63.7	-	-